



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АРХАНГАЙ АЙМГИЙН ХОТОНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитаар илэрсэн 25.5 сая төгрөгийн зөрчлийг эс тооцвол өмнөх
аудитуудаас өгөгдсөн зөвлөмж, холбогдох шийдвэрүүдийг
хэрэгжүүлэн ажиллаж байна гэж үзлээ.



АГУУЛГА:

Тайлан бэлтгэсэн

Товч үгийн тайлбар

Архангай аймаг дахь
Төрийн аудитын газар

Нэг: Ерөнхий зүйл

Тэргүүлэх аудитор
Д.Уламбаяр

Хоёр: Засаг даргын нөөц хөрөнгөөс төсөв хөрөнгөтэй холбоотой зарцуулахаар гарч буй шийдвэрүүдийн үндэслэлийг зөв, оновчтой гаргаагүй байна.

Аудитын менежер
Т.Байгалмаа

Ахлах аудитор
Ж.Мөнгөншагай

Гурав: Хотонт сумын ЗДТГазар нь өмч хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу бэлтгэж, зарцуулсан хэдий ч Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг хангалттай дагаж мөрдөөгүй байна.

Аудитор
Д.Должинсүрэн

Дүгнэлт

2018 оны 06 дугаар
сар

Зөвлөмж

Уг тайланг Аудитын
газрын www.audit.mn
вэб сайт-аас үзнэ үү

Тэргүүлэх аудиторовын тайлан баталгаажуулсан тушаал

Аудитын тайлан
дүнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах зүйл байвал
70332860 дугаарын
утас, харилцана уу

Холбогдох байгууллагын санал

Хаяг:
Эрдэнэбулган сум
Аймгийн ЗДТГ-ын байр
3 давхар 314 тоот

ТОВЧ ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын сатандарт
ЗДТГазар	Засаг даргын тамгын газар
ИТХурал	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХууль	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХууль	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын их хурал

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 АУДИТЫН НЭР:

Хотонт сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийх эрсдлийн аудит

1.2 АУДИТ КОД: АРА-/2018/01-ЭА

1.3 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.4 АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ

Хотонт сумын ЗДТГ-ын 2017 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт болон өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаад аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар санал зөвлөмж хүргүүлж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд аудитын зорилт оршилоо.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлийг баримтлана.

- Байгууллагын төсөв хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
- Өмч хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу бэлтгэж, зарцуулсан эсэх

1.5 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хотонт сумын Засаг даргын тамгын газар нь 2017 онд урсгал зардалд 593.7 сая төгрөгийн төлөвлөгдөн, гүйцэтгэлээр 593.7 сая төгрөгийг зарцуулжээ, нэмэлт төсвийн дансаар 3.9 сая төгрөгийн санхүүжилт орж ирснийг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Тус сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад “Төсвийн тухай” хуулийн холбогдох заалтыг зөрчиж төсвийн хөрөнгийг үр ашиггүй үрэлгэн зарцуулж байгууллагад хохирол учруулсан, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3.1.3-т заасан **“ашиг сонирхлын зөрчил”**, 3.1.11-т заасан **“ашиг сонирхолын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал”** үүссэн байж болзошгүй байх 84.9 төгрөгийн зөрчилтэй асуудлууд илэрсэн мөн жилийн эцэст байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, аймгийн Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг үндэслэн 73.5 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа

үндэслэл, шалтгааныг тодруулахгүйгээр зөвхөн тоолох үед байгаагүй, эвдэрч хэмхэрсэн, ашиглах боломжгүй гэсэн ерөнхий дүгнэлт үндэслэсэн байгаа нь өмч эзэмшигчид хариуцлага хүлээлгэхгүй орхигдуулах, хөрөнгийг үнэгүйдүүлэх, эзэнгүйдүүлэх, үрэгдүүлж завших зэрэг эрсдэл гарсан байж болзошгүй гэж үзэн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлтийг өгсөн бөгөөд аймгийн Цагдаагийн газарт 2018 оны 2 дугаар сарын 9-ны өдөрийн 26 тоот албан бичгээр дээрх 84.9 сая төгрөгийн зөрчилтэй асуудлыг мөн аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2018 оны 3 дугаар сарын 1-ны өдрийн 41 тоот албан бичгээр тайлант онд данснаас хасагдсан дээрх хөрөнгө, бараа материалын асуудлыг газар дээр нь шалгуулах хүсэлтийг хүргүүлсэн байна.

1.6 АУДИТЫН АРГА ЗҮЙ:

А[] гүйцэтгэхэд АОУС 315, АДБОУС 1315 Санхүүгийн аудитын аудитын журам, с[] ү[] санхүүгийн тайлангийн [] арга зүйг ашиглан анхан шатны баримтаас шалгаж, дүн шинжилгээ хийх, газар дээр нь тооллого, тооцоо хийх, [] байгууллага, албан тушаалтнаас []-а, [] санал асуулга [] []-аас тайлбар авах, [] ү[] [] үнэлэх дүгнэх [] ү[] лээ.

1.7 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1. Төсвийн тухай хууль
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
3. ТБОНӨХБАҮХАТХууль
4. Эд хариуцагчийн эрх, үүргийн дүрэм
5. Засгийн газрын 2014 оны 147 тогтоол
6. Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

1.8 АУДИТ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Аудитыг тэргүүлэх аудитор Д.Уламбаяр удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Ж.Мөнгөншагай, гэрээт аудитор Д.Должинсүрэн нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

1.9 АУДИТЫН ХУГАЦАА:

Аудитын төлөвлөлтийн үе шатныг ажлыг 2018 оны 05 сарын 01-ны өдрөөс эхлүүлж, талбарын ажлыг 2018 оны 05 сарын 04-нээс гүйцэтгэж аудитын тайлангийн төслийг 2018 оны 06 сарын 11-ны дотор Тэргүүлэх аудиторт танилцуулж, аудитын тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2018 оны 06 сарын 28-ны дотор холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

ХОЁР: АУДИТЫН ТАЙЛАН

2. БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВ ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН ЭСЭХ:

Засаг даргын нөөц хөрөнгөөс төсөв хөрөнгөтэй холбоотой зарцуулахаар гарч буй шийдвэрүүдийн үндэслэлийг зөв, оновчтой гаргаагүй байна.

2.1 ОРОН ТОО БОЛОН ЦАЛИН ХӨЛС, НЭМЭГДЭЛ УРАМШУУЛЛЫН ЗАРДЛЫН ТАЛААР:

Хотонт сумын ЗДТГазар нь тайлант онд Засгийн газрын 2015 оны 425 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн а/01 тоот захирамжаар баталсан орон тооны дагуу удирдах 3, гүйцэтгэх 18, үйлчлэх 2, гэрээт 4 нийт 27 албан хаагчидтай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан байна.

Тайлангийн жилд ЗДТГазрын ажилтан албан хаагчдад цалин хөлс, нэмэгдэлээр нийт 195.1 сая төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 21.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь холбогдох тогтоол, журмын дагуу байлаа. Цалинтай холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлд холбогдох хуулиудын дагуу бүрэн шилжүүлж авлага, өр төлбөргүй ажиллажээ.

2.2 БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ БУЮУ УРСГАЛ ЗАРДЛЫН ТАЛААР:

Тайлант онд нийт зардлын 21.1 хувь буюу 125.1 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд төсөвлөсний дагуу зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. /сая төгрөг/

№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13.0	13.0	
2	Хангамж, бараа материалын зардал	13.9	13.9	
3	Эд хогшил худалдан авах зардал	1.5	1.5	
4	Томилолт, зочны зардал	3.0	3.0	
5	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	0.5	0.5	
6	Бараа үйлчилгээний бусад зардал	93.2	93.2	
Нийт дүн		125.1	125.1	

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 3.6 сая төгрөгийг гэрэл цахилгаан, 9.4 сая төгрөгийг түлш халаалтын зардалд

- Хангамж, бараа материалын зардлын 2.6 сая төгрөгийг бичиг хэргийн зардал, 10.0 сая төгрөгийг тээвэр шатахууны зардал, 1.3 сая төгрөгийг шуудан холбоо, ном хэвлэлийн зардал
- Эд хогшил худалдан авах зардал буюу 1.5 сая төгрөг нь урсгал зардал
- Томилолт, зочны зардал 3.0 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлын 0.2 сая төгрөг нь аудит баталгаажуулалтын зардал, 0.3 сая төгрөг нь тээврийн хэрэгслийн татвар, даатгалын үйлчилгээний зардал
- Бараа үйлчилгээний бусад зардлын 2.2 сая төгрөг нь хичээл үйлдвэрлэлийн зардал, 90.0 сая төгрөг нь сумын засаг даргын нөөц хөрөнгө, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлуудад тус тус зарцуулагдсан байна.

Бараа үйлчилгээний бусад зардлаарх Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын дагуу зарцуулсан ч захирамжийн үндэслэл буруу гаргасантай холбоотой **14.2** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид сумын Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулалттай холбоотой шийдвэрийг гаргахдаа үндэслэлийг журамд нийцүүлж байхад анхаарах зөвлөмж хүргүүлээ.

2.3 УРСГАЛ ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРДЛЫН ТАЛААР:

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэгийн зардлаас 2017 онд сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн 3 багийн засаг даргад тус бүр 3.3 сая төгрөг буюу нийт 9.9 сая төгрөгийн тэтгэмжийг Төрийн албаны тухай хуулийн дагуу сумын Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 6/18 тоот захирамжаар олгожээ.

Харин нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас төрийн албан хаагчдад 7.8 сая төгрөгийг шийдвэрийн дагуу олгосон байна.

2.4 ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ТАЛААР:

Хөрөнгийн зардлаар бэлтгэсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хүснэгтээр харуулбал:

№	Хөрөнгийн ангилал	Хөрөнгийн нэр	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Барилга байгууламж	Цагаан сүм рашаан 0.4-н шугам	5.0
2		Худгын барилга	7.5
3		Мал нядалгааны хяналтын зах	50.0
4		Цэцэрлэгт хүрээлэн	85.0
5	Тон ог төх өөр өм ж	ЗДТГазарт Ланд 200 авто машин	49.9

**АРХАНГАЙ АЙМГИЙН ХОТОНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

6	Тавилга, эд хогшил	0.6
7	Компьютер, тоног төөхөрөмж	2.9
8	Турник хөтөлбөр	9.0
9	Шатахуун түгээх машин	20.0
10	Цагаан идээ борлуулах цэг	4.0
Нийт дүн		233.9

Дээрх хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой асуудлыг 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгаад “Төсвийн тухай” хуулийн холбогдох заалтыг зөрчиж төсвийн хөрөнгийг үр ашиггүй үрэлгэн зарцуулж, байгууллагад хохирол учруулсан мөн “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3.1.3-т заасан **“ашиг сонирхлын зөрчил”**, 3.1.11-т заасан **“ашиг сонирхолын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал”** үүссэн байж болзошгүй байх гэж үзсэн сумын ЗДТГазарт худалдан авсан 49.9 сая төгрөгийн Land 200 авто машин, Цэцэрлэгт хүрээлэнгийн 15.0 сая төгрөгийн зураг төсөв, шатахуун тээвэрлэлтийн авто машин худалдан авсан үнэ 20.0 сая төгрөг зэрэг нийт 84.9 сая төгрөгтэй холбоотой асуудлуудыг аймгийн Цагдаагийн газарт 2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 26 тоот албан бичгээр шилжүүлэн шалгуулсан бөгөөд аймгийн Прокурорын газраас тухайн шалгуулсан асуудалд хэрэг нээх үндэслэлгүй гэж үзсэн тухай тогтоол ирүүлсэн байна.

Иймд албан ажлын шаардлага хангахгүй гэсэн үндэслэл муутай санал гаргасан, хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг судалгаа тооцоогүй үндэслэлийг хяналгүй олгосноос дээрх зөрчил дутагдал үүсэх үндсэн нөхцөл болсон байна гэж үзэн аудитаас Орон нутгийн өмчийн газарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Харин эрсдэлийн аудитаар тухайн хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг биетээр үзэн шалгахад ямар нэгэн зөрчил үүсээгүй бөгөөд дээрх хөрөнгүүд бүртгэл тайланд тусгагдаж, бүрэн ашиглагдан үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байлаа.

3. ӨМЧ ХӨРӨНГИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ БЭЛТГЭЖ, ЗАРЦУУЛСАН ЭСЭХ:

Хотонт сумын ЗДТГазар нь өмч хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу бэлтгэж, зарцуулсан хэдий ч Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг хангалттай дагаж мөрдөөгүй байна.

Тайлант онд Хотонт сумын Засаг даргын тамгын газарт нийт 311.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэний 91.7 хувь буюу 285.8 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр

худалдан авсан бол 8.3 хувь буюу 25.7 сая төгрөгийн хөрөнгө нь бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй нэмэгдсэн байна.

Худалдан авсан нийт хөрөнгийн 81.8 хувь буюу 233.9 сая төгрөгийн хөрөнгийг сум, аймгийн ИТХурлаар батлуулж, ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан ба аймгийн Орон нутгийн өмчийн газраас 5 удаагийн зөвшөөрөл авч тухайн хөрөнгүүдийг байгууллагын хөрөнгийн бүртгэл, тайланд тусган ашиглаж байгаа бол 56.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газраас холбогдох хууль дүрэм журмын дагуу зөвшөөрөл авч актлаж устгасан байна.

3.2 Бараа материалын талаар:

Аудитаар сумын ЗДТГазрын бараа материалын тайланг шалгахад тээвэр шатахууны зарцуулалтыг шууд зардал болгон зарцуулсан нярав эд хариуцагчийн бүртгэлд тусгаагүй **11.3** сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д **“үнэн зөв байх”** гэсэн зарчим, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 2.10-д **“Мөнгөн хөрөнгө, бараа материалын үнэт зүйлийг хүлээн авах, тавьж олгох, борлуулах ажлыг дагалдах баримт, хуваарь, лимит зэргийг харгалзан үзэж өөрийн биеэр заавал шалган тоолж гүйцэтгэх ба баримт бичилтийн дүрмийн шаардлагын дагуу цаг тухайд нь цэвэр нямбай, засваргүйгээр үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна”** гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг мөрдөж ажиллах, шатахууны тооцоог үнэн зөв гаргаж хэвших, бүртгэл тайлагналд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ.

3.3 Хөрөнгө бараа материалын тооллого, тооцооны талаар:

Аудитын газраас хүргүүлсэн мэдэгдлийн дагуу Орон нутгийн өмчийн газраас ажлын хэсэг томилогдож ажилласан тухай 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 170 тоот албан бичиг ирүүлсэн бөгөөд ажлын хэсэг зарим багуудад бэлчээр хамгаалах зорилгоор баригдсан хашаанууд ашиглагдах боломжгүй буюу хашаа байхгүй байсан мөн мал угаах ваннуудад сүүлийн жилүүдэд засвар үйлчилгээ огт хийгдээгүй, ашиглах ямар ч боломжгүй болсон тухай хариу илрүүлсэнээс гадна актлуулахаар хүсэлт ирүүлсэн тавилга, эд хогшилыг газар дээр нь дахин үзэж тоолж хянаад өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтын байдлын талаарх зөрчлүүдэд өмч хөрөнгийн тооллогыг үнэн зөв, цаг хугацаанд нь хийж хэвших, өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг чадавхжуулах талаар зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан байна.

Тухайн ажлын хэсэг өмч хөрөнгийн тооллогыг хэрхэн хийсэн талаар дахин тодруулахад орон нутгийн өмчийн газраас тухайн байгууллагын өмч хөрөнгөнд бүртгэлтэй 824.4 сая төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж, 199.1 сая төгрөгийн

өртөг бүхий тээврийн хэрэгсэл, 64.9 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, 32.9 сая төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил, 1,022.2 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгүүдэд тооллого хийсэн гэсэн хариуг 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 242 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Харин эрсдэлийн аудитаар тухайн байгууллагын тайланд онд шинээр бэлтгэсэн 301.8 сая төгрөгийн хөрөнгөнд тооллого хийхэд тооллогод хамрагдсан хөрөнгүүдийн хадгалалт хамгаалалт хэвийн, бүрэн ашиглагдаж байлаа.

Жич: Тухайн сумын багуудад байршилтай үндсэн хөрөнгийг тооллогод хамруулах боломжгүй байлаа. Учир нь аудитын үеэр малын халдварт шүлхий өвчин гарсантай холбоотой хорио цээр тогтоосон байсан. Мөн сумын ЗДТГазрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар илэрсэн хөрөнгө актлаж устгасантай холбоотой зөрчлийг шалгуулахаар аймгийн Аудитын газраас Орон нутгийн өмчийн газарт 2018.03.01-ны өдрийн 41 тоот албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэний дагуу ажлын хэсэг томилогдож, өмч хөрөнгийг шалгаж хариуг ирүүлсэн болно.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үнэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

- **Аудитаар илэрсэн 25.5 сая төгрөгийн зөрчлийг эс тооцвол өмнөх аудитуудаас өгөгдсөн зөвлөмж, холбогдох шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна гэж үзлээ.**

Зөвлөмж:

ЗАРЛАГА

Илрүүлэлт

Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын дагуу зарцуулсан хэдий ч захирамжийн үндэслэл буруу гаргасантай холбоотой **14.2** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Зөвлөмж

Засаг даргын нөөц хөрөнгийг "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын дагуу захирамжийн үндэслэлийг зөв гаргаж зориулалтын дагуу зарцуулах

Эрсдэл

- Холбогдох журам, заавар зөрчигдөх
- Хөрөнгө зориулалт бус зарцуулагдаж улмаар хөрөнгийн зарцуулалтаас үр ашиг, үр дүн бий болохгүй байх
- Шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед нөөцийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах

Танилцаж зөвшөөрсөн:

Хотонт сумын ТЭЗахирагч

/Д.Батбаатар/

ЗДТГазрын дарга

/А.Оюунаа/

Нягтлан бодогч

/Г.Цэнгэлжаргал/

Арханай аймаг дахь Төрийн аудитын
газрын Ахлах аудитор

/ Ж.Мөнгөншагай/

Зөвлөмжийн хариуг 2018 оны 08 сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

АРХАНГАЙ АЙМГИЙН ХОТОНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



АРХАНГАЙ АЙМГИЙН
ХОТОНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

65040 Архангай аймаг, Хотонт сум, Хотонт-Ухаа

Утас: (976) 9997-9102

Э-мэйл: khotont11zdig@yahoo.com

2018.06.27

№

22/69

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой нэмж оруулах санал байхгүй болно.

ДАРГА



А.ОЮУНАА

D/my doc: A5